



## БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



### БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ХҮН АМ, ӨРХИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, ТӨЛӨВ БАЙДАЛ **/2016 ОН/**



ӨЛГИЙ ХОТ 2017 он

## АГУУЛГА

1.Судалгааны агуулга, зорилт	4
2. Хүн ам зүйн байдал	5
3.Хүн амын шилжих хөдөлгөөн	6
4.Суурин хүн амын бүтэц ба өсөлт	9
5.Хүн ам зүйн үзүүлэлтүүд	13
6.Өрхийн тоо	15
7.Ажиллагсад салбарын ангилалаар	16
8.Хүн амын хүйс, байршил	17
9.Хүн амын дундаж наслалт	20
10. Өвчлөл, нас баралт, эхийн эндэгдэл шалтгаанаар	22
11. Өрхийн ам бүлийн байдал	25
12.Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо	27
13. Хүн амын нийгмийн асуудал	28
14. Хүн ам өрхийн бүртгэл, шинэ ажлын байр	30
15.Дүгнэлт	33

\_\_\_\_\_ о О о \_\_\_\_\_

**Танилцуулгыг хийж нэгтгэсэн, хянан боловсруулсан:**

Х.Бахыт

---

---

Санал хүсэлт байвал доорх  
хаягаар холбоо барина уу.

Баян-Өлгий аймгийн Статистикийн хэлтэс  
Засаг даргын тамгын газрын байр

Е-mail: [bayan-ulgii@nso.mn](mailto:bayan-ulgii@nso.mn)

Утас: 70422322

Интернет хаяг: [//www.nso.mn/bayan-ulgii/](http://www.nso.mn/bayan-ulgii/)

Баян-Өлгий аймгийн Статистикийн хэлтэс

Өлгий хот, 2017 оны 4 сар



## БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ХҮН АМ, ӨРХИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ, 2016 ОНД

### А. Судалгааны зорилго

Баян-Өлгий аймгийн хүн ам зүйн үзүүлэлтүүдийн өнөөгийн түвшин, Монгол улсын хэмжээнд болон бүс нутгийн хэмжээнд ямар түвшинд явж байгаа, хүн ам зүйн өсөлт, шилжих хөдөлгөөний хандлага, бүтэц, ачаалал, ажил эрхлэлт, ажилгүйчүүдийн түвшинг тооцож, үнэлэлт, дүгнэлт өгөхөд орших ба мөн тус аймгийн удирдлага болон хэрэглэгчдийг хүн ам, өрхийн төлөв байдлын талаар дэлгэрэнгүй мэдээллээр хангах зорилготой болно.

Төр засгаас авч хэрэгжүүлсэн бодлого шийдвэрийн хэрэгжилт, төсөл хөтөлбөрийн үр дүнг дүгнэж үнэлэх, цаашидын бодлого, зорилтоо тодорхойлох, тоон мэдээллийн хэрэглээнд статистикийн шинжилгээний аргуудыг ашиглан шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийг боловсруулах, зохистой ашиглахад үндсэн хэрэгсэл болно. Статистикийн салбарыг хөгжүүлэх дунд хугацааны үндэсний хөтөлбөрт Статистикийн тогтолцоог бэхжүүлэх, аргачлал, ангилал, шинжилгээ, судалгааг төгөлдөржүүлэх, үндэсний тооцооны системийг нэвтрүүлэх, салбарын статистикийг хөгжүүлэх, хүний нөөцийн чадавхийг дээшлүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ гэж заасан байдаг. Өмнөх жилүүдийн хүн ам, нийгмийн статистикийг хөгжүүлэх дэд зорилт нь хүн амын бүртгэлийг сайжруулж, хүн ам, өрхийн мэдээллийн нэгдсэн цахим сан үүсгэх, хүн ам зүй, нийгмийн статистикийн мэдээллийн чанарыг дээшлүүлэн олон улсын хэмжээнд хэрэглэж байгаа нийтлэг арга зүйд нийцүүлэх, ядуурал, ажилгүйдэл, хүн амын амьжиргааны түвшин, хэрэглээний үндсэн үзүүлэлтүүдийг орон нутгийн түвшинд тооцдог болгоход чиглүүлэх зорилт дэвшүүлж эдгээр зорилтуудыг хэрэгжүүлсэнээр тодорхой үр дүнд хүрсэн. Жил бүр хүний хөгжил, хүн ам зүйн үндсэн үзүүлэлтүүдийг аймаг болон бүс нутгаар тооцож зэрэгцүүлэх, орон нутгийн түвшинд хүн ам зүйн үзүүлэлтүүдийг тооцох, улсын дундажтай харьцуулсан судалгаа хийх үнэлэлт дүгнэлт хийх шаардлага зүй ёсоор гарч байна.

### Б. Судалгааны агуулга

Аливаа улсын нийгэм эдийг засгийн хөгжил нь тухайн орон хүн ам зүйн бодлогоо хэрхэн боловсруулж, хэрхэн яаж хэрэгжүүлэхээс шууд шалтгаална. Эдийн засаг, нийгмийн хөгжилд хүн амын тоо, насны бүтэц, өсөлтийн түвшин гэсэн 3 гол хүчин зүйл нөлөөлнө. Хүн амын өсөлт, бүтэц, байршил болон түүнд гарч буй өөрчлөлтүүд, үйлдвэрлэл ба хэрэглээний тогтвортой бус хандлага, өсөн нэмэгдэж буй ядуурал, хүрээлэн буй орчны бохирдол зэрэг хүчин зүйлсүүдийг харилцан уялдаатай авч үзэх шаардлага гардаг.

Хүн амын өсөлтийн түвшин өндөр байх тусам хөрөнгө оруулалт өндөр байдаг гэсэн үзэл баримтлал ч байдаг. Энэ талаар авч үзэхэд боловсролын түвшинээс хамааран хүн амын өсөлт, нөхөн үржихүйн үзүүлэлтүүд ихээхэн ялгаатай гардагийг улсын хэмжээнд явагдсан судалгаануудад тусгасан байдаг. Хүн амын тогтвортой өсөлтийн хангах гол үзүүлэлт бол хүн амын цэвэр өсөлт мөн. Эдгээр шаардлагын үүднээс сүүлийн 4 жилийн харьцуулсан судалгааг хийсэн болно.




**ХҮН АМ ЗҮЙН БАЙДАЛ**

**АЙМГИЙН ХҮН АМЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД**

Үзүүлэлтүүд	хэмжих нэгж	2012	2013	2014	2015	2016	$\frac{2016}{2015} \%$
Хүн амын тоо	тоо	88952	90878	93165	97787	99346	101.6
Төрсөн хүүхэд- бүгд	тоо	2546	2762	2789	2770	2831	102.2
1000 хүнд ногдох төрөлт	коэф	28.6	30.4	30.7	28.3	28.5	100.7
Нас барсан- бүгд	тоо	441	452	470	534	515	96.4
1000 хүнд ногдох нас баралт	коэф	5.0	5	5.2	5.5	5.2	94.5
Цэвэр өсөлт: 1000 хүнд ногдох	коэф	23.6	25.4	25.5	22.8	23.3	102.2
Эдийн засгийн идэвхитэй хүн ам	мян.хүн	51.5	50.9	46.4	49.5	44.3	89.5
Ажиллагсдын тоо	мян.хүн	45.1	34.3	35.9	43.6	42.9	98.4
Ажилгүйчүүд-бүгд	тоо	1042	1349	1534	1124	1320	117.4
Хөдөлмөр эрхлээгүй хүн ам-Бүгд	мян.хүн	12.4	23.5	22.5	11.9	9.3	78.2
Ажилгүйдлийн түвшин/ХХҮГазар/	коэф	2.0	2.7	3.3	2.3	3.0	131.2
Ажилгүйдлийн түвшин/АХСудалгаа/	коэф	24.1	46.2	48.5	24.0	21.0	87.3

2016 оны жилийн эцсийн байдлаар аймгийн суурин хүн амын тоо 99.3 мянга болж урьд оныхоос 1.6 хувиар нэмэгдэж өссөн болно. Энэ нь тухайн жилийн хүн амын ердийн хөдөлгөөнийг бүрэн тусгаж, хүн ам өрхийн мэдээллийн сан болон Улсын бүртгэлийн хэлтсийн иргэний мэдээллийн сангийн зөрүүг арилгаж, бичиг баримтын зөрчилтэй хүмүүсийн зөрчлийн арилгуулж мэдээллийн санд тусгагдаж цэгцлэгдсэнээр нэмэгдэж гарсан. 1000 хүнд ногдох төрөлт 28.5, нас баралт 5.2, цэвэр өсөлт 23.3 болсон нь төрөлт өмнөх оныхоос 0.2 пунктээр нэмэгдэж, нас баралт 0.3 пунктээ багассаг, цэвэр өсөлт 0.5 пунктээр нэмэгдсэн байна.

**ХҮН АМЫН ЦЭВЭР ӨСӨЛТ**



Аймгийн хүн амын 58.3 хувь нь 16-59 насны хүмүүс байгаа нь хөдөлмөрийн хангалттай нөөц байгааг харуулж байна. Хүн амын 36.6 хувийг 15 хүртэлх

насны хүүхдүүд, 5.1 хувийг 60-аас дээш насны ахмад настангууд эзэлж байна.Өнгөрсөн жил тус аймагт 270 хүн шилжин ирж, дотоод шилжих хөдөлгөөнөөр 446 хүн Улаанбаатар хот болон хөрш зэргэлдээ аймаг руу шилжин суурьшиж, урьд онуудад Казахстан улс руу шилжин суурьшсан 2124 хүн Монгол улсын иргэншлээс гарсан байна.Хүн амын тооны өсөлтөнд зөвхөн шилжих хөдөлгөөн нөлөөлж байснаас биш манай аймагт 1000 хүнд ногдох хүн амын цэвэр өсөлт улсын дундажаас буурч байгаагүй юм.2012 онд хөдөлмөрийн гэрээгээр болон өөрийн хүсэлтээр гадаадад гарагсдын тоо 567 байсан бол 2013 онд 103, 2014 онд 216, 2015 онд 822, 2016 онд 2124 болж өмнөх жилийнхээс 2.6 дахин нэмэгдсэн байна.

### ХҮН АМЫН ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН

Үзүүлэлтүүд	2012	2013	2014	2015	2016
Шилжин ирэгсэд бүгд:	95	233	218	262	270
Шилжин явагсад бүгд:	862	614	695	1328	2570
'Үүнээс: Казахстан руу	567	103	216	822	2124

2015 онд нийт 1328 хүн шилжин явсаны 61.9 хувийг гадаад руу буюу Казахстан улс руу шилжих шилжилт, 38.1 хувийг манай улсын нийслэл буюу томоохон хот суурин газар руу чиглэлдсэн дотоод шилжилт эзэлж байсан бол 2016 онд 2570 хүн шилжин явсаны 82.6 хувийг гадаад руу буюу Казахстан улс руу, 17.4 хувийг улсын нийслэл буюу томоохон хот суурин газар руу чиглэлдсэн шилжилт эзэлж байна.Гадаад руу хөдөлмөрийн гэрээгээр 1991-2000 оны хооронд зөвхөн манай аймгаас 57.2 мян хүн шилжин сууршсан байсан.1991-2010 он хүртэл хөдөлмөрийг гэрээгээр болон суралцахаар 77.0 мянган казах иргэд шилжин явсан ба түүний 52.5 мянга нь зөвхөн манай аймгаас шилжсэн гэсэн тооцоо бий.

### ДОТООД ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН, ШИЛЖИН ЯВАГСАД

Он	Шилжин явсан өрх-Бүгд	Шилжин явсан хүн ам-Бүгд	Үүнээс: насны бүтцээр			
			0-14 насны	15-29 насны	30-54 насны	55-аас дээш
2012 онд	41	567	52	386	114	15
2013 онд	68	103	18	62	23	
2014 онд	74	216	20	68	128	
2015 онд	280	822	36	230	368	109
2016 онд	105	446	75	280	72	19
Улаанбаатар хот	70	298	47	198	44	9
Ховд	22	92	16	54	15	7
Увс	4	18	6	6	5	1
Сэлэнгэ	3	10	3	4	3	
Бусад аймаг	6	28	3	18	5	2

### ДОТООД ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН, ШИЛЖИН ИРЭГСЭД

Он	Шилжин ирсэн өрх- Бүгд	Шилжин ирсэн хүн ам-Бүгд	Үүнээс: насны бүтцээр			
			0-14 насны	15-29 насны	30-54 насны	55-аас дээш
2015 онд	61	262	85	109	56	12
2016 онд	64	270	64	140	55	11
Улаанбаатар хот	31	133	26	67	33	7
Ховд	16	68	18	44	5	1
Увс	8	33	12	13	8	
Сэлэнгэ	2	9	3	3	3	
Орхон	2	8	2	5	1	
Бусад аймаг	5	19	3	8	5	3

### ГАДААД ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН, НАСНЫ БҮЛГЭЭР

Он	Шилжин явсан өрх- Бүгд	Шилжин явсан хүн ам-Бүгд	Үүнээс: насны бүтцээр			
			0-14 насны	15-29 насны	30-54 насны	55-аас дээш
2000 он хүртэлх шилжилт	9130	42020	12926	14430	12630	2037
2010 он хүртэлх шилжилт	2210	10470	3459	3193	3283	545
2011 онд	192	918	313	261	310	34
2012 онд	41	567	52	386	114	15
2013 онд	68	103	18	62	23	
2014 онд	74	216	20	68	128	
2015 онд	280	822	36	230	368	109
2016 онд	498	2124	426	727	827	144

2000 он хүртэл хөдөлмөрийн гэрээгээр ажилчин элсүүлэн авсан учир нийт шилжигсэдийн 49.1 хувийг 15-54 насны хөдөлмөрийн насны хүн ам, 9.1 хувийг их дээд сургуульд суралцагчид эзэлж байна. Бусад 41.8 хувийг тэдний үр хүүхдүүд болон хамт амьдардаг тэтгэврийн насны хүмүүс эзэлж байна. 1997 оноос хойш шилжилт багассан ба 2005 онд 612 гэр бүлийн 2848 хүн, 2010 онд 457 өрхийн 2203 хүн шилжин суурьшсан, 2015 онд 280 өрхийн 822, 2016 онд 498 өрхийн 2124 хүн Казахстан руу шилжиж бүртгэлээс хасагдсан бөгөөд 2015, 2016 ондуудад Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлигаар иргэншлээс гарсан хүнийг тооцож оруулсан болно. 2016 онд өрхөөрөө шилжигсэд өөрөөр хэлбэл 30-дээш насны хөдөлмөрийн насныхан, гадаадад суралцаж төгсөөд тэнд ажиллахаар үлдэгсэд, ажил хөдөлмөр эрхлэхээр явагсад давамгайлж байна.

Казахстанд их дээд сургуулиуд улсын тэтгэлэгээр степендтэй суралцуулах сургалтын системтэй болохоор шилжигсэдийн 51,7 хувь нь суралцахаар, 11,3 хувь нь хөдөлмөрийн насны хүн ам буюу ажиллахаар

явагсад эзэлж байна. 2016 оны шилжин явагсадын 34.2 хувийг 15-29 насны залуучууд эзэлж, 20.1 хувийг 0-14 насны хүүхэдүүд, 38.9 хувийг 30-54 насны хүн ам эзэлж байна.

### ХҮН АМ ЗҮЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Үзүүлэлтүүд	2012	2013	2014	2015	2016
Хүн амын тоо	88952	90878	93165	97787	99346
Цэвэр өсөлт	23.7	25.4	25.5	24	23.3
Төрөлтийн ерөнхий коэффициент**	28.6	30.4	29.9	28.3	28.5
Төрөлтийн тусгай коэффициент	105.5	111.5	112.7	106.8	107.0
Төрсөн хүүхэд, Бүгд	2546	2762	2789	2770	2831
15-49 насны эмэгтэй	24143	24771	24743	25930	26460
1000 хүнд ногдох нас баралт	5.0	5.0	5.2	5.7	5.2
Хүйсний бүтэц:Эрэгтэй	44475	45436	46624	48720	49538
Эмэгтэй	44477	45438	46541	49067	49808
Хүйсний харьцаа*	100.0	100.0	100.2	99.3	99.5
Нялхасын нас баралтын коэффициент	23.2	17.4	23.7	24.9	27.9
Нялхсын эндэгдэл /0-1 нас/	59	48	66	69	79
1-5 хүртэлх насны хүүхдийн нас баралт	12	18	8	18	12
Батлуулсан гэр бүл	702	620	968	992	794
Гэрлэлтийн ерөнхий коэффициент	0.79	0.68	1.04	1.01	0.80
Гэрлэлтийн тусгай коэффициент**	1.2	1.1	1.6	1.6	1.2
Гэр бүл салалт	31	56	39	28	34
15-аас дээш насны хүн ам	56972	58424	59474	63389	65073

\*100 эрэгтэйд тооцох эмэгтэйчүүдийн тоо

\*\* Нөхөн үржихүйн насны 1000 эмэгтэйд ногдох төрөлт

\*\*\* Гэрлэх насанд хүрсэн 100 хүнд ногдох гэрлэлт

Хүн ам зүйн зарим үзүүлэлтүүдийн тооцооноос үзэхэд төрөлтийн ерөнхий коэффициент 2000 онд 32.3 байсан бол 2010 онд 27.1 болтол буурсан бол 2012 оноос эхлэн жил дараалал өсч 2016 онд 28.5 болсон нь тус аймагт төрөлт улсын дундажаас 1.4 пунктээр их байна. 2016 онд өмнөх оныхоос 0.2 пунктээр өсч, 1000 хүнд ногдох нас баралт 5.2 промилль болж өмнөх оныхоос 0,5-аар багассан байна. Төрөлтийн тусгай коэффициентээс харахад 2016 оныг 2012 онтой харьцуулахад 0.1 промилльээр буурч, өмнөх 2015 оныхоос 0.2 хувиар нэмэгдсэн нь төрөлт өмнөх оноос 2.2 хувиар өсч нөхөн үржихүйн 15-49 насны эмэгтэйчүүдийн хувийн жин нэмэгдэж байгааг харуулж байна.Төрөлтийн ерөнхий коэффициент буурч байх үед хүн ам зүйн ачаалал өндөр байгаа нь манай аймгийн хүн амын төрөлтийн түвшин өмнөх жилүүдэд өндөр, дундаж наслалт уртсаж байгаатай холбоотой юм.Хүйсний харьцаанаас үзэхэд эмэгтэйчүүд болон эрэгтэйчүүдийн хүйсний харьцаа ойролцоо түвшинд байна.



Эрэгтэйчүүдтэй /49.5 мян хүн/ харьцуулахад эмэгтэйчүүдийн /49.8 мян хүн/ тоо цөөхөн тоогоор их /270 хүн/ байгаа бөгөөд 100 эмэгтэйд 100 эрэгтэйд ногдож байна. Хүн амын өсөлтийг илэрхийлэх бас нэг үзүүлэлт бол гэрлэлтийн ерөнхий болон тусгай коэффициент юм.

Гэрлэлтийн ерөнхий коэффициент 2010 онд 2000 онтой харьцуулахад 26.2 хувиар, тусгай коэффициент мөн адил 34.5 хувиар буурсан бол 2016 онд 2015 онтой харьцуулахад гэрлэлт багассаг, гэрлэлтийн ерөнхий коэффициент 0.21 пунктээр, гэрлэлтийн тусгай коэффициент 0.4 пунктээр буурч, гэр бүл салалт өмнөх оноос 21.4 хувиар өссөн байна. 2016 онд 794 гэр бүл бүртгүүлсэн нь өмнөх оныхоос 19.9 хувиар бага байна. 2013 онд 56 хүрч нэмэгдсэн бол 2014 онд 39, 2015 онд 28, 2016 онд 34 гэр бүл салсан нь өмнөх оныхоос 6 гэр бүлээр өссөн байна.

### ХҮН АМЫН НАСНЫ БҮТЭЦ СУУРИН ХҮН АМЫН ТОО, СУМААР

Сумын нэр	2012	2013	2014	2015	2016	<u>2016%</u> 2015
Алтай	3631	3722	3983	4143	4212	101.7
Алтанцөгц	2738	2654	2684	2787	2792	100.2
Баяннуур	4623	4750	4794	4825	4913	101.8
Бугат	3251	3384	3487	3626	3781	104.3
Булган	5020	4928	5216	5095	5144	101.0
Буянт	2438	2476	2592	2698	2767	102.6
Дэлүүн	6720	6823	6994	7118	7140	100.3
Ногооннуур	5457	5643	6003	6278	6307	100.5
Сагсай	4669	4874	4945	5046	5137	101.8
Толбо	3839	3875	3939	4037	4105	101.7
Улаанхус	7340	7660	8010	8299	8357	100.7
Цэнгэл	7952	8291	8744	8943	9149	102.3
Өлгий	29875	30404	30338	33420	34007	101.8
Цагааннуур	1399	1394	1436	1472	1535	104.3
<b>Дүн</b>	<b>88952</b>	<b>90878</b>	<b>93165</b>	<b>97787</b>	<b>99346</b>	<b>101.6</b>


Хүн амын цэвэр өсөлт өмнөх оноос 0.7 пунктээр буурсан ч суурин хүн амын тоо өмнөх жилийнхээс нэмэгдсэн нь дараах хүчин зүйлүүдтэй холбоотой байна.

Үүнд:

- Гадаадад Монгол улсын харьяатаас гарахгүйгээр удаан хугацаагаар оршин суугчдын тооноос хамаарч байна.
- Хүн ам, өрхийн бүртгэлийн мэдээллийн сангийн баяжилт сайжирч, цахим хэлбэрт оруулах явцад хаягийн шилжилт хийлгэхгүйгээр өөр аймаг хотуудад ажиллаж амьдардаг хүн нилээд байгаагаас шалтгаалж байна.
- Ерөнхий боловсролын сургууль төгсөгчдийн тоо нэмэгдэж 6 сараас

дээш хугацаагаар өөр газар суралцаж байгаа оюутанууд тухайн газрын бүртгэлд бүрэн хамрагдаж ороогүйгээс шалтгаалж байна.

### ХҮН АМЫН ТОО, ЦЭВЭР ӨСӨЛТ



### СУУРИН ХҮН АМЫН ТОО, БҮГД

Сумын нэр / Нас	Бүгд	0	1	2	3	4	5	6
Алтай	4212	99	123	137	106	106	103	81
Алтанцөгц	2792	56	68	65	63	60	71	47
Баяннуур	4913	105	133	118	139	125	111	116
Бугат	3781	98	111	109	110	72	98	77
Булган	5144	111	140	116	129	135	123	116
Буянт	2767	81	75	73	84	57	49	53
Дэлүүн	7140	189	185	188	194	172	177	153
Ногооннуур	6307	181	180	193	196	164	167	185
Сагсай	5137	132	145	177	161	123	130	105
Толбо	4105	105	101	110	114	80	105	74
Улаанхус	8357	178	233	236	248	225	198	202
Цэнгэл	9149	225	257	269	240	244	235	206
Өлгий	34007	775	946	922	858	806	792	739
Цагааннуур	1535	43	39	49	44	33	48	37
<b>Дүн</b>	<b>99346</b>	<b>2378</b>	<b>2736</b>	<b>2762</b>	<b>2686</b>	<b>2402</b>	<b>2407</b>	<b>2191</b>

Сумын нэр / Нас	7	8	9	10	11	12	13	14
Алтай	88	101	87	87	63	87	87	82
Алтанцөгц	68	66	68	54	47	59	67	59
Баяннуур	127	124	109	102	97	118	134	111
Бугат	83	89	79	79	80	82	92	80
Булган	112	112	107	104	103	104	120	109
Буянт	74	59	44	46	40	66	46	47
Дэлүүн	131	173	150	157	152	163	168	167
Ногооннуур	168	164	144	140	132	125	127	124
Сагсай	132	115	113	121	98	106	105	100
Толбо	102	112	95	85	93	81	94	83
Улаанхус	222	200	197	196	183	165	200	178
Цэнгэл	225	235	224	199	189	223	222	186
Өлгий	716	736	657	612	562	613	656	626
Цагааннуур	35	30	35	28	20	27	20	25
Дүн	2283	2316	2109	2010	1859	2019	2138	1977

Сумын нэр / Нас	15	16	17	18	19	20-24	25-29
Алтай	78	99	79	87	81	414	385
Алтанцөгц	61	66	54	54	61	281	242
Баяннуур	127	106	109	88	94	490	423
Бугат	78	82	72	61	80	371	364
Булган	112	99	98	116	88	533	450
Буянт	49	66	58	64	46	292	221
Дэлүүн	178	156	165	116	154	754	565
Ногооннуур	105	86	117	118	127	611	584
Сагсай	137	115	111	115	80	509	460
Толбо	89	93	85	84	78	432	336
Улаанхус	196	171	191	154	166	867	672
Цэнгэл	201	209	183	189	183	906	812
Өлгий	643	682	619	602	536	3265	3446
Цагааннуур	27	25	28	36	21	141	151
Дүн	2081	2055	1969	1884	1795	9866	9111

Хөдөлмөрийн насны хүн ам нийт хүн амын 52.4 хувийг эзэлж, 42.5 хувийг хүүхэдүүд, 5.1 хувийг өндөр настан эзэлж байна. Хөдөлмөрийн насны 1000 хүн 813 хүүхэд, 97 өндөр настанг асран тэжээх үүрэг ногдож байна.

Сумын нэр / Нас	30-34	35-39	40-44	45-49	50-54	55-59	60+
Алтай	315	287	251	205	151	131	212
Алтанцөгц	171	201	182	136	119	84	162
Баяннуур	314	288	276	230	195	135	269
Бугат	262	232	236	180	125	91	208
Булган	382	321	286	252	218	160	288
Буянт	201	192	168	139	118	110	149
Дэлүүн	498	459	383	340	270	209	374
Ногооннуур	503	418	322	243	206	170	307
Сагсай	353	327	269	208	174	136	280
Толбо	256	266	232	222	167	89	242
Улаанхус	595	531	443	401	281	202	426
Цэнгэл	643	581	491	407	315	245	405
Өлгий	2672	2188	2114	1820	1573	1152	1679
Цагааннуур	140	104	93	78	67	42	69
Дүн	7305	6395	5746	4861	3979	2956	5070

Төрөлтээс шалтгаалан 15-аас доош насны хүн амын эзлэх хувь 2000 онд 41.0 хувиас 2010 онд 36.8 хувь, 2013 онд 35.7 хувь болтол буурсан бол 2014 онд 36.1, 2015 онд 37.3, 2016 онд 42.5 хувь болж өмнөх оноос 5.2 пунктээр нэмэгдсэн байна.

#### ХӨДӨЛМӨРИЙН НАСНЫ 1000 ХҮН АМД НОГДОХ ТЭЖЭЭВЭР ХҮНИЙ ТОО

Сумын нэр	хөдөлмөр- ийн насны хүн ам	хүүхэд	өндөр настан	Бүгд	хөдөлмөрийн насны 1000 хүнд ногдох		
					хүүхэд	өндөр настан	Бүгд
Алтай	2,220	1780	212	4212	802	95	897
Алтанцөгц	1,477	1153	162	2792	781	110	890
Баяннуур	2,445	2199	269	4913	899	110	1009
Бугат	1,941	1632	208	3781	841	107	948
Булган	2,690	2166	288	5144	805	107	912
Буянт	1,487	1131	149	2767	761	100	861
Дэлүүн	3,632	3134	374	7140	863	103	966
Ногооннуур	3,184	2816	307	6307	884	96	981
Сагсай	2,516	2341	280	5137	930	111	1042
Толбо	2,078	1785	242	4105	859	116	975
Улаанхус	4,158	3773	426	8357	907	102	1010
Цэнгэл	4,583	4161	405	9149	908	88	996
Өлгий	18,766	13562	1679	34007	723	89	812
Цагааннуур	837	629	69	1535	751	82	834
Дүн	52014	42262	5070	99346	813	97	910

## ХҮН АМ ЗҮЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

*Хүн ам зүйн ачаалал:* Хөдөлмөрийн насны 100 хүнд ногдох хүүхэд, хөгшдийн харьцаагаар илэрхийлэгддэг үзүүлэлт юм.

*Хөгшрөлтийн индекс:* 0-15 насны хүүхэд, 65, түүнээс дээш настай хүн амын харьцаа

*Голч нас:* Хүн амын тоог таллан хувааж байгаа зааг нас

*Асран хамгаалагчийн харьцаа:* 50-64 насны 100 эмэгтэйд ногдох 80-аас дээш насныхны харьцаа

Эдгээр хүн ам зүйн ачаалал 2000 онд 0.85 байсан бол 2010 онд 0,72, 2013 онд 0,69 болж буурсан бол 2014 онд 0,70, 2015 онд 0,69 болж өмнөх оноос 0,01 пунктээр буурав. Нийт хүн амын дотор хүүхдийн хувийн жин настайчуудаас өндөр учраас хөгшрөлтийн индекс 2015 онд өмнөх жилийнхээс буурч гарсан байна. Манай аймгийн хувьд голч нас бол 20.8 нас байна. Асран хамгаалах 50-64 насны 100 эмэгтэйд 14 хүн ногдож байна.

## ХҮН АМ ЗҮЙН АЧААЛАЛ

Үзүүлэлтүүд	2012	2013	2014	2015	2016
0-15 насны хүн ам	31980	32454	33691	36525	36354
Хөдөлмөрийн насны хүн ам	52505	53845	54650	56893	58447
Өндөр настаны тоо	4467	4579	4824	4643	5070
Хүн ам зүйн ачаалал	0.69	0.69	0.70	0.72	0.71
Хөгшрөлтийн индекс	10.30	12.30	14.32	12.71	13.95

## АЙМГИЙН ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ИНДЕКС

Үзүүлэлтүүд	2012	2013	2014	2015
Хүн амын дундаж наслалтын индекс	0.796	0.803	0.812	0.82
Хүн амын боловсролын түвшний индекс	0.609	0.606	0.602	0.586
Нэг хүнд ногдох ҮНО-ын индекс	0.531	0.565	0.586	0.589
Хүний хөгжлийн индекс	0.636	0.65	0.659	0.657
Улсын дүнгээр	0.718	0.726	0.735	0.735
Жендерийн хөгжлийн индекс, аймаг-Эмэгтэй	0.737	0.747	0.755	0.757
Жендерийн хөгжлийн индекс, аймаг-Эрэгтэй	0.708	0.716	0.726	0.724

\*ҮНО-Үндэсний нийт орлого

Хүний хөгжлийн индексээр манай аймаг 2015 онд өмнөх оныхоос боловсролын түвшний индекс 0.02 пунктээр буурч, дундаж наслалтын индекс 0.008 пунктээр, нэг хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүн буюу үндэсний нийт орлогын индекс 0.003 пунктээр нэмэгдсэн боловч хүний хөгжлийн индекс өмнөх оныхоос 0.02 пунктээр буурч, жендерийн индекс өөрчлөгдөөгүй 0.74

байна. Хүний хөгжлийн индекс улсын дундажаас 0.078 пунктээр бага байгаа нь хот хөдөөгийн ялгааг харуулж байна.

### АЖИЛЛАГСДЫН ТОО, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАРААР


№	Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	2014	2015	2016	2016 % 2015
1	Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	15756	24248	22672	93.5
2	Уул уурхай, олборлолт	311	146	162	111.0
3	Боловсруулах үйлдвэрлэл	1313	1386	1402	101.2
4	Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	81	239	248	103.8
5	Усан хангамж, бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	48	59	72	122.0
6	Барилга	1608	1858	1876	101.0
7	Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ	5890	5570	5482	98.4
8	Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	1941	1770	1652	93.3
9	Зочид буудал, байр сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	272	100	342	342.0
10	Мэдээлэл, холбоо	346	231	246	106.5
11	Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	403	288	316	109.7
12	Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	30	49	52	106.1
13	Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	533	104	164	157.7
14	Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	43	142	148	104.2
15	Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	2070	2225	2276	102.3
16	Боловсрол	3660	3422	3878	113.3
17	Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	863	1207	1276	105.7
18	Урлаг, үзвэр, тоглоом наадам	443	305	316	103.6
19	Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	227	139	247	177.7
20	Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа	30	45	48	106.7
21	Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	87	88	89	101.1
<b>Дүн</b>		<b>35955</b>	<b>43621</b>	<b>42964</b>	<b>98.5</b>

Манай аймагт нийт хүн амын 43.2 хувийг, хөдөлмөрийн насны хүн амын 82.6 хувь нь буюу 42.9 мянган хүн эдийн засгийн үйл ажиллагааны ямар нэгэн салбарт ажил эрхэлж, 9.0 мянган хүн ажил хөдөлмөр эрхэлдэггүй нь хөдөлмөрийн насны хүн амын 17.4 хувийг эзэлж байна. Өөрөөр хэлбэл хүүхэд, өндөр настангуудыг оролцуулаад ажил эрхэлдэг нэг хүн 3 хүнийг тэжээж байна. Нийт ажиллагсдын тоо 42.9 мянга байгаагийн 52.8 хувь нь хөдөө аж ахуйн салбарт, 5.3 хувь нь төрийн захиргаа, батлан хамгаалах, 12.8 хувь бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэгчид, 9.1 хувийг боловсролын салбарт, 3.0 орчим хувийг эрүүл мэндийн салбарын ажиллагсад тус тус эзэлж байна.

### ӨРХИЙН ТОО

Сумын нэр	2013	2014	2015	2016	2016-2015	$\frac{2016}{2015}\%$
Алтай	1042	1091	1 093	1122	29	102.7
Алтанцөгц	712	713	736	749	13	101.8
Баяннуур	979	1084	1 088	1151	63	105.8
Бугат	920	918	926	972	46	105.0
Булган	1120	1160	1 182	1183	1	100.1
Буянт	654	717	747	768	21	102.8
Дэлүүн	1501	1572	1 551	1594	43	102.8
Ногооннуур	1372	1449	1 486	1549	63	104.2
Сагсай	1170	1192	1 202	1250	48	104.0
Толбо	909	939	947	970	23	102.4
Улаанхус	1634	1741	1 746	1819	73	104.2
Цэнгэл	1820	1937	1 941	2001	60	103.1
Өлгий	6983	7531	7 637	7 792	155	102.0
Цагааннуур	355	367	380	402	22	105.8
<b>Дүн</b>	<b>21171</b>	<b>22411</b>	<b>22 662</b>	<b>23 322</b>	<b>660</b>	<b>102.9</b>

### Хүн амын жилийн өсөлтийн хувь



2015\*-Хүн ам, орон сууцны завсрын тооллого

### НЭГ ӨРХӨД НОГДОХ ХҮНИЙ ТОО

Сумын нэр	2012	2013	2014	2015	2016
Алтай	3.5	3.6	3.7	3.8	3.8
Алтанцөгц	3.8	3.7	3.8	3.8	3.7
Баяннуур	4.8	4.9	4.4	4.4	4.3
Бугат	3.7	3.7	3.8	3.9	3.9
Булган	4.5	4.4	4.5	4.3	4.3
Буянт	3.8	3.8	3.6	3.6	3.6
Дэлүүн	4.5	4.5	4.4	4.6	4.5
Ногооннуур	4.1	4.1	4.1	4.2	4.1
Сагсай	4.1	4.2	4.1	4.2	4.1
Толбо	4.4	4.3	4.2	4.3	4.2
Улаанхус	4.6	4.7	4.6	4.8	4.6
Цэнгэл	4.7	4.6	4.5	4.6	4.6
Өлгий	4.3	4.4	4.0	4.4	4.4
Цагааннуур	3.9	3.9	3.9	3.9	3.8
Дүн	4.3	4.3	4.2	4.3	4.3


Нэг өрхөд ногдох хүний тоогоор сумаар авч үзэхэд Цэнгэл, Улаанхус, Дэлүүн, Өлгий, Баяннуур сумдад 4.3-4.6 хүнтэй байхад, Ногооннуур, Сагсай, Толбо, Бугат сумдад 3.9-4.1 хүнтэй байна. Хамгийн баг нь Алтай, Алтанцөгц, Буянт сум орж 3.6-3.8 хүн ногдож байна.

### ХҮН АМЫН ТОО, БАЙРШИЛ, СУМААР

Сумын нэр	2015 оны хүн ам		2016 оны хүн ам	
	аймаг сумын төвд	хөдөө	аймаг сумын төвд	хөдөө
Алтай	1,073	3 070	1,067	3 136
Алтанцөгц	865	1 922	869	1 993
Баяннуур	2,025	2 800	2,034	3 040
Бугат	1,202	2 424	1,245	2 480
Булган	1,056	4 039	1,033	4 367
Буянт	718	1 980	741	2 018
Дэлүүн	1,729	5 389	1,746	5 567
Ногооннуур	1,711	4 484	879	4 658
Сагсай	1,512	3 534	1,487	3 599
Толбо	1,161	2 876	1,174	2 947
Улаанхус	2221	6 078	2247	6 232
Цэнгэл	2305	6 638	2356	6 889
Өлгий	33,420		34,007	
Цагааннуур	1,555		1,535	
дүн	52,553	45 234	52,420	46 926



### Хүн амын байршил




Сумын нэр	2015 оны өрхийн тоо		2016 оны өрхийн тоо	
	аймаг, сумын төвд	хөдөө	аймаг, сумын төвд	хөдөө
Алтай	277	816	391	731
Алтанцөгц	217	519	259	490
Баяннуур	459	629	476	675
Бугат	309	617	379	593
Булган	242	940	371	812
Буянт	205	542	208	560
Дэлүүн	379	1 172	401	1 193
Ногооннуур	423	1 063	471	1 078
Сагсай	378	824	452	798
Толбо	270	677	371	599
Улаанхус	485	1 261	300	1 519
Цэнгэл	511	1 430	781	1 220
Өлгий	7 637		7 665	127
Цагааннуур	380		402	
<b>Дүн</b>	<b>12172</b>	<b>10 490</b>	<b>12927</b>	<b>10 395</b>

Аймгийн нийт хүн амын 53.0, өрхийн 55.0 хувь нь хот суурин газар аймгийн болон сумын төвд, хүн амын 47.0 хувь, хүн амын 47.0 хувь, өрхийн 45.0 хувь нь хөдөө амьдарч байна. 2010 онд нийт хүн амын 49.3 хувь хөдөө амьдардаг байсан ба хөдөөнөөс аймаг, төв суурин газар руу, гадаад руу чиглэгдсэн шилжих хөдөлгөөн их байгаагаас эдгээр харьцаа төв суурин газруудад давамгайлж байна. Үүнтэй уялдан хөдөө аж ахуйд ажиллагсдын тоо 2015 оныхоос 6.5 хувиар буурч, одоо нийт ажиллагсдын 52.8 хувийг хөдөө аж ахуйн салбарт ажиллагсад эзэлж байна. Жинхэнэ хөдөө суурьшиж мал маллан амьдардаг өрхийн тоо 2012 онд 8383, 2013 онд 8392, 2014 онд 8921, 2015 онд 8872 болж өмнөх оноос 49 өрхөөр буурч, харин 2016 онд 16 өрхөөр нэмэгдсэн байна.

### ӨРХ, МАЛЧДЫН ТОО


	2012	2013	2014	2015	2016	2016/2015
Малчин өрх	8383	8392	8921	8872	8888	100.2
Малчдын тоо	17808	17723	18302	18398	18411	100.1
Үүнээс:16-34 т	8644	8120	7693	7396	6927	93.7
35-59 насны Тэтгэврийн насны	7902	8249	9117	9433	9884	104.8
Нэг малчин өрхөд ногдох мал	168	191	211	227	244	107.5

### Өрхийн байршил




Жилийн дөрвөн улирал малаа өөрөө малладаг малчдын тоо 2012 онд 17.8 мянгаас 2016 онд 18.4 мянга болж нэмэгдсэн нь улсаас ноосны урамшууллыг зөвхөн малчин өрхүүдэд олгодог, мөн сүүлийн жилүүдэд хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний үнэ, түүний дотор ноолуурын үнэ өсч малчин өрхийн орлого болон амьжиргааны эх үүсвэр болж байгаа холбоотой. Аймаг дотроо шилжих шилжилт зөвхөн сумдаас аймгийн төв рүү чиглэгдсэн байдаг. Энэ нь хүн амын тоонд нөлөөлөхөөргүй байгаа боловч, аймаг дотор хүн амын бүтэц, байршилд зохих хэмжээгээр нөлөөлж байна.

### ХҮН АМЫН ТОО, ХҮЙСЭЭР



сумын нэр	Байнга хүн ам	Үүнээс		дүнд эзлэх хувь	
		Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй
Өлгий	34007	16798	17209	49.4	50.6
Алтай	4212	2138	2074	50.8	49.2
Алтанцөгц	2792	1371	1421	49.1	50.9
Баяннуур	4913	2519	2394	51.3	48.7
Бугат	3781	1908	1873	50.5	49.5
Булган	5144	2580	2564	50.2	49.8
Буянт	2767	1392	1375	50.3	49.7
Дэлүүн	7140	3522	3618	49.3	50.7
Ногооннуур	6307	3170	3137	50.3	49.7
Сагсай	5137	2564	2573	49.9	50.1
Толбо	4105	2053	2052	50.0	50.0
Улаанхус	8357	4184	4173	50.1	49.9
Цэнгэл	9149	4588	4561	50.1	49.9
Цагааннуур	1535	751	784	48.9	51.1
<b>ДҮН</b>	<b>99346</b>	<b>49538</b>	<b>49808</b>	<b>49.9</b>	<b>50.1</b>




Дээрх хүснэгтээс үзэхэд аймгийн дүнгээр эрэгтэйчүүд ба эмэгтэйчүүд хувийн жин ойролцоо түвшинд байна. Баяннуур, Алтай, Бугат, Буянт, Ногооннуур, Улаанхус, Цэнгэл сумдад эрэгтэйчүүдийн хувийн жин 0.1-1.3 хувиар давамгайлж байна. Харин Дэлүүн, Алтанцөгц, Өлгий, Сагсай сум, Цагааннуур тосгонд эмэгтэйчүүдийн хувийн жин 0.1-1.1 хүртэлх хувиар илүү байна.

### СУУРИН ХҮН АМЫН БҮТЭЦ

Хүн амын нас хүйсийн 2016 оны суврагаас харахад 0-4, 5-9 насны бүлгийн насны хүн амын тоо хамгийн их буюу 24.3 мянга буюу нийт хүн амын 24.4 хувийг эзэлж байгаа нь дөрвөн хүн тутмын нэг нь бага насны хүүхэд эзэлж хүн амын залуу бүтэцтэй байгааг харуулж байна. 2012 онд нийт хүн ам 88.9 мянга байсан бол 5 жилийн дотор хүн амын бүтэцэнд өөрчлөлт орж 2016 онд суурин

хүн амын тоо 99.3 мянга болж 11.7 хувиар өссөн байна. Сүүлийн 5 жилд төрөлт буураагүй, 1000 хүнд ногдох төрөлт улсын дундаж 27.1 байхад тус аймагт 28.5 байгаа нь 1.5 пунктээр их буюу өндөр байгаа нь 0-4 насны хүүхэд 12.9 мянга болж нийт хүн амын 13.1 хувийг эзэлж байна.

### ХҮН АМЫН НАС ХҮЙСНИЙ СУВАРГА



Хүн амын дундаж наслалт уртассантай холбоотойгоор 60-аас дээш настай өндөр настангуудын хувийн жин нэмэгдсэн нь суврагын толгойн хэсэг өргөсөж үүний дотор эмэгтэйчүүдийн тоо эрэгтэйчүүдээс илүү байгаа нь харагдаж байна. Дээрх хүн амын нас, хүйсийн суваргаас харахад суурь хэсэг нь өргөн, дунд хэсгээрээ жигд өргөсч байгаа нь хүн ам идэрших хандлагатай байгааг харуулж байна. 2016 онд 0-4 насны хүн амын тоо 5-9 насны хүн амын тооноос их байгаа нь сүүлийн 5 жилд төрөлт нэмэгдсэнтэй холбоотой юм. 2016 оны суваргын 10-14, 15-19, 20-24 насны хүн амын тоо харилцан ижилхэн харьцангуй их хувийн жинг эзэлдэг нь харагдаж байна.

### ХҮН АМЫН ДУНДАЖ НАСЛАЛТ

Үзүүлэлтүүд	2011	2012	2013	2014	2015
Улсын дундаж	68.32	68.71	69.11	69.57	69.89
Үүнээс: Эрэгтэй	64.68	64.91	65.42	65.91	66.02
Эмэгтэй	73.76	74.32	75.01	75.49	75.84
Баян-Өлгий	70.97	71.74	72.16	72.76	73.33

Эрэгтэйчүүдийн нас барах магадлал эмэгтэйчүүдээс их байдаг учир нас ахих тусам хүйсний харьцаа буурч байдаг. Улсын хэмжээнд дундаж наслалт эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс 9,5 насаар илүү байгаа нь хүйсний харьцаанд


нөлөөлж байдаг.

Хүн амын улсын дундаж наслалт 2015 онд 2010 онтой харьцуулахад 1.8 насаар, 2014 онтой харьцуулахад 0.32 насаар уртассан бол манай аймгийн хүн амын дундаж наслалт 2015 онд 2010 оноос 3.5 насаар, 2014 оноос 0.6 насаар өссөн байна. Дундаж наслалтаар манай аймаг улсын дундажаас 3.4 насаар илүү байна.

**1000 ХҮНД НОГДОХ ТӨРӨЛТ, НАС БАРАЛТ, СУМААР**

Сумын нэр	Төрөлт					Нас баралт				
	2012	2013	2014	2015	2016	2012	2013	2014	2015	2016
Алтай	22.0	26.9	35.9	30.4	30.4	3.9	7.3	5.0	7.8	7.6
Алтанцөгц	22.3	23.0	23.5	26.1	21.5	7.7	6.0	8.2	7.8	5.4
Баяннуур	23.8	27.8	28.0	32.5	24.8	3.2	5.1	3.5	5.2	5.3
Бугат	23.4	26.3	31.0	27.5	29.4	5.8	4.7	3.7	8.0	5.0
Булган	30.1	26.8	23.4	28.9	28.6	4.4	5.5	4.4	4.4	5.6
Буянт	22.1	30.7	28.2	25.1	28.2	5.3	5.3	5.4	4.6	7.2
Дэлүүн	21.7	27.7	28.0	30.0	30.4	4.0	5.4	4.0	5.4	6.2
Ногооннуур	32.2	35.8	34.3	33.3	31.1	6.0	4.6	5.7	5.8	5.7
Сагсай	28.5	31.4	35.0	33.0	31.0	4.7	4.1	6.1	5.1	5.8
Толбо	23.4	27.4	23.9	26.4	24.8	4.9	5.4	6.1	6.1	6.1
Улаанхус	29.6	32.2	31.5	31.2	26.3	3.5	4.2	4.4	7.5	5.1
Цэнгэл	31.7	30.4	30.2	31.3	31.6	6.7	6.8	6.4	6.1	5.5
Өлгий	26.1	32.3	30.3	28.6	28.1	4.8	4.2	4.7	5.0	4.0
Цагааннуур	25.1	30.1	29.2	29.2	29.3	5.7	6.5	7.7	4.9	6.5
Аймгийн дундаж	24.3	30.2	31.4	28.6	28.5	5.0	5.4	5.4	6.0	5.2
Улсын дундаж	26.0	27.5	28.0	27.1	27.6*	6.3	5.9	5.6	5.8	5.7*

\*-Урьдчилсан гүйцэтгэл



Хүн амын тоо, бүтэц шилжилтээс гадна нас баралт, төрөлтөөс шалтгаалан байнга өөрчлөгдөж байдаг. Сумдын хүн амын тоон үзүүлэлтүүдийг хоорондоо харьцуулах сумын хүн амын том багаас хамааран ач холбогдол багатай байдаг. Эдгээр өөрчлөлтийн тоон үзүүлэлтээс гадна 1000 хүнд ногдох

промилээр илэрхийлэх нь сумдын хүн амын тооны их бага өөрчлөлтийг тусгахгүйгээр харьцуулах боломжтой болдог. 1000 хүнд ногдох төрөлт 2016 онд Цэнгэл, Ногооннуур, Сагсай, Алтай, Дэлүүн сумуудад аймгийн дундажаас 1.5-3.1 пунктээр их, Алтанцөгц, Баяннуур, Толбо, Өлгий, Буянт, Бугат сумуудад 0.3-7.0 пунктээр бага байна. Эрүүл мэндийн салбарт шинэ техник, технологи нэвтэрч өвчтөний өвчний оношыг эрт илэрүүлэн шат шатандаа авч буй арга хэмжээ болон хүн амын дунд эрүүл мэндийн боловсролд тодорхой ахиц гарсаны үр дүнд нас баралт өмнөх оноос 0.8 пунктээр буурсан байна.

### **ХҮН АМЫН ӨВЧЛӨЛ, НАС БАРАЛТЫН ШАЛТГААН**

Хүн амын эрүүл мэндийн үзүүлэлтүүдийн нэг нь бол өвчлөл, эндэгдлийг шалтгаанаар нь бүртгэж хамгийн их гэснийг тэргүүлэх шалтгаан гэж үздэг.

Сүүлийн 5 жилийн өвчлөлийг үзэхэд жил тутам амсгалын тогтолцооны өвчин, шээс бэлгийн замын өвчин, хоол шингээх тогтолцооны өвчин цусны эргэлтийн тогтолцооны өвчин голлон тэргүүлсэн хэвээрээ байгаа ба бэртэтг хордлого бага хувийг эзэлж, мэдрэлийн системийн тогтолцооны өвчин давамгайлсан байна. Энэ нь нэг талаас эрс тэс уур амьсгалын өөрчлөлт, одоогийн амьдралын хэв шинжийн нөхцөл байдалтай холбож үзэж болохоор байна.

### **ХҮН АМЫН ӨВЧЛӨЛИЙН ТЭРГҮҮЛЭХ 5 ШАЛТГААН, 10 000 ХҮН АМД НОГДОХ**

д/д	Шалтгаан	2012	2013	2014	2015	2016
	Амьсгалын тогтолцооны					
1	өвчин	462.9	8.6	420.5	980.2	912.1
	Хоол шингээх					
2	тогтолцооны өвчин	277.3	379.6	387.6	683.0	599.8
	Шээс бэлгийг замын					
3	тогтолцооны өвчин	385.3	441.6	423.9	714.3	642.9
	Цусны эргэлтийн					
4	тогтолцооны өвчин	248.7	433.1	431.0	663.0	687.5
	Мэдрэлийн системийн					
5	тогтолцооны	95.9	91.9	191.8		
	Бэртэл, хордлого ба					
	бусад гадны шалтгааны					
6	үр дагавар				109.5	300.3

2016 онд өвчлөгсдийн дотор амьсгалын тогтолцооны өвчнөөр өвчлөгсөд хамгийн өндөр үзүүлэлттэй байна. Дарааллаар нь цусны эргэлтийн тогтолцооны өвчин хоёр дугаарт, шээс бэлгийн тогтолцооны өвчин гурав дугаарт, хоол шингээх тогтолцооны өвчин дөрөвт, бэртэл хордлого ба бусад гадны шалтгааны үр дагавар тавдугаарт бичигдэж байна. Цаг агаарын огцом өөрчлөлтөөс хамаараад амьсгалын тогтолцооны өвчин, цусны эргэлтийн тогтолцооны өвчин, бэртэл хордлого ба бусад шалтгаан өвчин давамгайлж байна. Мэдрэлийн системийн тогтолцооны өвчнүүд энхий таван шалтгаанд ороогүй байна.

### ХҮН АМЫН НАС БАРАЛТЫН ТЭРГҮҮЛЭХ 5 ШАЛТГААН, 10 000 ХҮН АМД НОГДОХ

д/д	Шалтгаан	2012	2013	2014	2015	2016
	Амьсгалын тогтолцооны					
1	өвчин	7.2	5.14	5.7	4.7	5.5
	Хоол шингээх					
2	тогтолцооны өвчин	6.4	5.14	4.6	3.7	3.2
	Цусны эргэлтийн					
3	тогтолцооны өвчин	20.9	20.8	18.9	24.2	20.4
	Бэртэл, хордлого ба					
4	бусад гадны шалтгааны		3.83	3.5	3.6	3.4
5	Хавдар	6.9	8.74	10.8	10.6	11.1
	Төрөх тойны үед үүсэх					
6	зарим оёг					
	Шээс бэлгийг					
7	тогтолцооны өвчин	1.7				

Цусны эргэлтийн тогтолцооны өвчнөөр нас барагсад нийт нас барагсдын 24.2 хувийг эзэлж тэргүүлэх шалтгаан болоод байна. Хавдараар нас барагсдын тоо сүүлийн жилүүдэд нэмэгдэж 2 дахь шалтгаанд ороод байна. Амьсгалын тогтолцооны өвчин болон хоол шингээх тогтолцооны өвчнөөр нас барагсад нийт нас барагсдын дотор 4.7-3.7 хувийг эзлэж байна. 10000 хүн ам тутмын 3 нь гаднах шалтгаант өчнөөр нас барсан гэсэн тоо гараад байна. 2016 онд шээс бэлгийн тогтолцооны өвчнөөр нас барагсад эхний 5 шалтгаанд орж ирсэн нь энэ төрлийн өвчин газар авах шинжтэй байна. Нас баралтын хамгийн их хувийг эзэлдэг амьсгалын тогтолцооны өвчин, цусны эргэлтийн өвчинөөр нас барагсад өмнөх оныхоос 0.4-3.8 пунктээр буурч, харин хавдаар нас барагсад 0.5 пунктээр өсөөн байна.

### ЭХИЙН ЭНДЭГДЛИЙН ТЭРГҮҮЛЭХ ШАЛТГААН

д/д	Шалтгаан	2012	2013	2014	2015	2016
1	Цус алдалт	1				
2	Эклампси		1			
	Экстрагениальный					
3	эмгэгүүд					
4	Төрсний дараах хүндрэл	2	3	1	2	1

### ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, АЙМГИЙН ДҮНГЭЭР

Үзүүлэлтүүд	2012	2013	2014	2015	2016
0-1 насандаа эндсэн хүүхэд	59	48	66	69	79
1-5 хүртэлх насандаа эндсэн хүүхэд	12	18	8	18	12

Төрсөн эхийн тоо нийтдээ 2831 болсон нь өнгөрсөн оныхоос 61 хүүхдээр их байна. Эхийн эндэгдэл болон нялхасын эндэгдэл бол эрүүл мэндийн чанарын гол үзүүлэлт болдог. 2016 онд эхийн эндэгдэл гараагүй бөгөөд харин нялхасын эндэгдэл 79 гарч өмнөх оноос 10 хүүхэд буюу 14.5 хувиар өссөн байна. Нялхсын эндэгдэл жил дараалан дорвитой буурч чадахгүй байгаа нь улсын хэмжээнд анхаарлын төвд байгаа гол асуудал болоод байна. Нялхасын эндэгдэл буурахгүй байгаагийн гол шалтгаан нь эцэг эхчүүдийн боловсролтой холбоотой, мөн нийгмийн эмзэг бүлэгийн дунд төрөлт өндөр байгаа нь хоол хүнсний хомсдол, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж зэрэгээс их нөлөөлж байна. Эрүүл эхээс эрүүл хүүхэд төрнө гэсэн зарчимын асуудал байгаа бөгөөд эхчүүдийн эрүүл мэндэд эхний ээлжинд анхаарах, гэр бүл төлөвлөлтийн талаархи мэдлэгийг дээшлүүлэх нь их чухал байна. Тогтвортой хөгжлийн зорилтын шалгуур үзүүлэлтүүдэд нялхасын эндэгдэл болон тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг 2010 онтой харьцуулахад 4 дахин бууруулах зорилт тавьсан нь 0-1 насны хүүхдийн эндэгдэл сүүлийн 5 жилд жил тутам тогтвортой буурахгүй байгаа гэж үзээд 2014 оныг эх хүүхдийн эрүүл мэндийн сахин хамгаалах жил болгон зарлаад бодитой зорилт дэвшүүлсэн ажилласан.

### 0-1 НАСНЫ БОЛОН 1-5 ХҮРТЭЛХ НАСНЫ ХҮҮХДИЙН ЭНДЭГДЛИЙН ТЭРГҮҮЛЭХ ШАЛТГААН, 1000 АМЬД ТӨРӨЛТӨД

№	Шалтгаан	2012		2013		2014		2015		2016	
		0-1 нас хүртэлх насны	1-5 хүртэлх насны	0-1 нас хүртэлх насны	1-5 хүртэлх насны	0-1 нас хүртэлх насны	1-5 хүртэлх насны	0-1 нас хүртэлх насны	1-5 хүртэлх насны		
1	Амьсгалын тогтолцооны өвчин	14.9	0.5	9.4	2.9	9.3	1.1	8.0	2.2	12.7	1.7
2	Перианаталь үед үүссэн зарим эмгэг			3.3		7.2		11.2		38.9	
3	Хоол шингээх тогтолцооны өвчин	1.2	0.1	1.1		1.1	0.4	1.1	0.4	1.0	0.7
4	Төрөлхийн гажиг өнгөт цогцын гажуудал	5.1	0.2	2.2	0.7	3.9	0.4	2.5	0.4	7.2	0.3
5	Бэртэл, хордлого ба гадны шалтгааны үр дагавар		0.4		0.7		0.4		2.2	1.4	0.7
6	Мэдрэлийн тогтолцоо	1.2	0.2	1.1	0.7	1.1	0.4	0.7	1.1	1.7	0.3
7	Дотоод шүүрэл	0.8			0.7						



Нялхасын эндэгдлийн гол шалтгаан нь перианталь үед үүссэн зарим эмгэгүүд, амьсгалын замын тогтолцооны өвчнүүд эзэлж байна. 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн тэргүүлэх шалтгааныг амьсгалын тогтолцооны өвчнүүд, бэртэл хордолого ба гадны шалтгааны үр дагавар эзэлж байна.

1000 амьд төрөлтөд ногдох нялхасын эндэгдэл баруун бүсэд 20, улсын дундажаар 15 байсан бол манай аймгийн дундаж 24 болж баруун бүсээс 4 пунктээр, улсын дундажаас 9 пунктээр илүү байгаа нь эх хүүхдийн эрүүл мэндээс, эцэг эхийн боловсрол мэдлэгийг түвшингээс, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжээс шалтгаалж байна.

Тогтвортой хөгжлийн зорилтын шалгуур үзүүлэлтүүдэд нялхасын эндэгдэл болон тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг 2010 онтой харьцуулахад 4 дахин бууруулах зорилт тавьсан нь 0-1 насны хүүхдийн эндэгдэл сүүлийн 5 жилд жил тутам тогтвортой буурахгүй байгаа гэж үзээд 2014 оныг эх хүүхдийн эрүүл мэндийн сахин хамгаалах жил болгон зарлаад бодитой зорилт дэвшүүлсэн ажилласан. 1000 амьд төрөлтөд ногдох нялхасын эндэгдэл баруун бүсэд 20, улсын дундажаар 15 байсан бол манай аймгийн дундаж 24 болж баруун бүсээс 4 пунктээр, улсын дундажаас 9 пунктээр илүү байгаа нь эх хүүхдийн эрүүл мэндээс, эцэг эхийн боловсрол мэдлэгийг түвшингээс, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжээс шалтгаалж байна.

### **ӨРХИЙН АМ БҮЛИЙН БАЙДАЛ**

Ядуурлын түвшинг хүн амын амьжиргааны доод түвшинг үндэслэн жил бүр шинэчлэн тооцдог бөгөөд ядуурлыг үндсэн 3 үзүүлэлтээр хэмждэг, үүнд: ядуурлын хамралтын хүрээ, ядуурлын гүнзгийрэлт, ядуурлын мэдрэмж. Ядуурлын түвшин хот суурин газрыг бодоход хөдөө илүү байгаа нь өрхөд суурилсан нийгэм эдийн засгийн судалгааны үр дүнгээр гарч байгаа ба ядуурлын хамралтын хүрээ улсын дундаж 21.6 хувьтай, үүнээс хот суурин газар 18.8 хувь, хөдөөд 26.4 хувьтай, баруун бүсэд 26.0 хувьтай, суурьшилаар авч үзвэл аймгийн төвд 23.8 хувь, сумын төвд 24.7 хувь, хөдөөд 27.9 хувьтай, ядуурлын гүнзгийрэлт улсын дундаж 5.2 хувь, баруун бүсэд 5.3 хувь, аймгийн төвд 5.8 хувь, сумын төвд 5.7 хувь, хөдөөд 6.0 хувьтай, ядуурлын мэдрэмж улсын дундаж 1.9 хувь, баруун бүсэд 1.7 хувь, аймгийн төвд 2.1 хувь, сумын төвд 2.0 хувь, хөдөөд 1.9 хувьтай байна. Хөдөөгийн хүн ам зах зээлээс хэт алслагдсаны зэрэгцээ боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж хязгаарлагдмал, мал аж ахуйгаас бусад ажлын байр хомс, мэдээлэл түргэн шуурхай хүргэх боломж сул байгаа нь тэдний амьдралын түвшин доройтоход хүргэж байна. Байгаль цаг уурын нөлөөлөлөөс амьдрал ахуй нь шууд хараат байдалтай байгаа нь нүүдлийн мал аж ахуйтай, жилийн дөрвөн улирал малаа бэлчээрээр малладаг уулархаг бүс, хадлан тэжээлийн нөөц багатай манай аймгийн хувьд хөдөөгийн хүн амын амьжиргаа нь доройтож ядуурлын хамрах хүрээ тууштай буурахгүй байна.

Монгол улсын хүн амд амьжиргааны доод түвшингээс доогуур орлоготой хүн амын эзлэх хувь 2000 онд 39.9 хувь, 2010 онд 38.8 хувь болж ядуурал харьцангуй гүнзгийрсэн байсан бол төр, засагаас ядуурлыг бууруулах, ажил эрхлэлтийг дэмжих, шинэ ажлын байр бий болгох шат дараалсан хөтөлбөр

хэрэгжүүлсэний үр дүнд 2014 онд нийт өрхөд ядуу өрхийн эзлэх хувь улсын дундаж 21.6 хувь, баруун бүсэд 26.0 хувь болж урьд онуудаас 17.2 пунктээр буурсан байна. Амьдралын гол эх үүсвэр нь мал аж ахуйтай шууд холбоотой хөдөөгийнхэний хувьд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнэ болон мал, малын ашиг шим, ноолуурын үнэ өссөн нь өрхийн амьжиргааг тэтгэж байгаа ч төв суурин газарт ядуу өрхийн тоо нэмэгдэж, нийт өрхөд эзлэх ядуу өрхийн хувийн жин 30.8 хувь болж нэмэгдсэн байна. Нийт ядуу өрхөд нэн ядуу өрхийн эзлэх жин 55.6 хувь болж өмнөх оныхоос 2.2 хувиар нэмэгдсэн байна.

Ядуурал бол дэд бүтцийн хөгжилтэй холбоотой ба нөгөө талаас төвөөс хэт алслагдсан хэрэглээний өртөг өндөр байгаатай мөн холбоотой байна.

### ХҮН АМЫН НИЙГМИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Үзүүлэлтүүд	2012	2013	2014	2015	2016*	$\frac{2016}{2014} \%$
Хөдөлмөр эрхлээгүй хүн ам	12.4	23.5	22.5	11.9	9.3	78.2
Ядуу өрхийн тоо	6525	6304	6686	6923	7184	103.8
Нэн ядуу өрхийн тоо	2983	3463	2844	3697	3993	108.0
8 ба дээш ам бүлтэй өрх	682	693	945	726	1054	145.2
Өрх толгойлсон эмэгтэй	1971	1841	1814	1871	1822	97.4
Ганц бие өрхийн тоо	188	220	186	207	254	122.7
Хөгжлийн бэрхшээлтэй иргэд	4305	4349	4461	4516	4564	101.1
Хагас өнчин хүүхдийн тоо	2313	2129	1904	1842	1862	101.1
Бүтэн өнчин хүүхдийн тоо	319	272	253	281	273	97.2

\*-урьдчилсан тоо

Өмнөх жилүүдэд харьцангуй өвөлжилт хэвийн, малын ашиг шимийн бүтээгдэхүүний үнэ нэмэгдсэн, төрөөс малчдын орлогыг нэмэгдүүлэх зорилгоор ноос, ноолуурын үнийн зөрүүг олгож эхэлсэн нь мал бүхий иргэдийн амьжиргааг дэмжиж тэтгэсэн бодлого болсон байна. Манай аймгийн нийт хүн амын 66.0 хувь нь сумын төв, хөдөө амьдардаг ба тэдний амьжиргаа нь мал аж ахуйтай шууд холбоотой учраас цаг агаарын өөрчлөлт, малын болон ашиг шимийн үнийн өөрчлөлтөөс шууд хамааралтай байна.

2016 онд аймгийн дүнгээр нийгмийн эмзэг бүлэгт ордог бүтэн өнчин хүүхдийн тоо 273 болж өмнөх оноос 2.8 хувиар нэмэгдэж, хагас өнчин хүүхдийн тоо 1842 болж өмнөх жилийнхээс 3,3 хувиар багассан нь нэг талаар нас дэвшиж байгаатай холбоотой бөгөөд нөгөө талаараа ам бүлээрээ, ах дүү нарыгаа бараадаж шилжих хөдөлгөөнд орох нь их байдагтай холбоотой байна. Үүний дотор 0-4 насны 13 хүүхэд байгаа нь бүтэн өнчин хүүхдийн 4.8 хувийг, 5-9 насны 43 хүүхэд байгаа нь нийт бүтэн өнчин хүүхэдийн 15.8 хувийг, 10-14 насны 80 хүүхэд байгаа нь өнчин хүүхэдийн 29.3 хувийг, 15-17 насны 137 хүүхэд нийт өнчин хүүхэдийн 50.2 хувийг, хагас өнчин 0-4 насны 192 хүүхэд нийт хагас өнчин хүүхэдийн 10.3 хувийг эзэлж байна. Өрх толгойлсон 1822 эмэгтэй байгаа нь 2015 оноос 49 өрх толгойлсон эх буюу 2.6 хувиар багассаг,

эмэгтэйчүүдийн өрх толгойлох, хүүхэд асран хүмүүжүүлэх үүрэг ачаалал өндөр хэвээрээ байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо 2014 онд 4461, 2015 онд 4551, 2016 онд 4564 хүн болж өмнөх оноос 0.3 хувиар нэмэгдэж, нийт хөгжлийн бэрхшээлтэй хүний 52.1 хувийг эмэгтэйчүүд, 4.7 хувийг хүүхэд, 60.9 хувийг төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй хүн эзэлж байна. Хөгжлийн бэрхшээлийн төрлөөр үзвэл 12.9 хувийн харааны бэрхшээлтэй хүн, 24.5 хувийг хөдөлгөөний бэрхшээлтэй хүн, 11.2 хувийг сэтгэцийн өөрчлөлттэй хүн, 4.8 хувийг ярианы, 6.5 хувийг сонсголын бэрхшээлтэй хүн, 6.6 хувийг хавсарсан хөгжлийн бэрхшээлтэй хүн эзэлж байна. 6 ба дээш ам бүлтэй өрхийн тоо 6271 болсон нь нийт өрхийн 26.9 хувийг эзэлж байна. Ганц бие өрхийн тоо 2015 онд 207, 2016 онд 254 өрх болж өмнөх оноос 47 өрхөөр нэмэгдсэн байна.

### ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТОО

Сумын нэр	2014	2015	2016	Үүнээс:		Хөгжлийн бэрхшээлийн төрөл	
				Эмэгтэй	0-14 насны хүүхэд	Төрөлхийн	Олдмол
Алтай	78	115	79	39	6	75	4
Алтанцөгц	87	90	88	38	8	77	11
Баяннуур	291	297	302	172	7	197	105
Бугат	159	161	196	87	9	156	40
Булган	484	587	544	292	25	260	284
Буянт	156	163	158	102	5	94	64
Дэлүүн	403	408	401	195	34	380	21
Ногооннуур	310	291	392	178	12	215	177
Сагсай	220	248	148	73	56	81	67
Толбо	347	442	446	277	8	222	224
Улаанхус	430	450	492	153	6	275	217
Цэнгэл	339	283	306	219	27	223	83
Өлгий	1157	1016	1012	555	13	525	487
<b>Дүн</b>	<b>4461</b>	<b>4551</b>	<b>4564</b>	<b>2380</b>	<b>216</b>	<b>2780</b>	<b>1784</b>

Хөгжлийн бэрхшээлийн төрөл	2016	Үүнээс:
		Эмэгтэй
Харааны	592	265
Хөдөлгөөний	1118	556
Сэтгэцийн өөрчлөлт	509	289
Ярианы	220	105
Сонсголын	296	130
Хавсарсан хөгжлийн бэрхшээл	299	138
Бусад	1530	897
<b>Дүн</b>	<b>4564</b>	<b>2380</b>

### ХҮН АМЫН НИЙГМИЙН АСУУДАЛ

Монгол улсын эдийн засаг 2008-2011 онд жилд дундажаар 7.7 хувь, 2012-2015 онд жилд дундажаар 8.5 хувиар өсч, сүүлийн арван жилийн хугацаанд эдийн засгийн өсөлт ойролцоогоор 8.0 хувьтай байсан боловч үр ашгийн хуваарилалт тэгш бус байгаагийн улмаас хүн амын 20 орчим хувь нь ядуурлын түвшнээс доогуур амьдарсан хэвээр байна. Тиймээс эдийн засгийн өсөлтийг хүртээмжтэй болгох, нийт ард түмний, ялангуяа ядуу, эмзэг бүлгийн иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэхийн тулд нийгмийн хамгааллыг сайжруулах асуудал нэн чухал бөгөөд нийгмийн хамгааллын суурь түвшний үзэл баримтлалыг боловсруулж, амьдралд хэрэгжүүлэх нь ядуурлыг буруулж, эдийн засгийн өсөлтийг хүртээмжтэй болгох арга замын нэг юм.

#### **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОСОН ТЭТГЭВЭРҮҮД**

/мянган төгрөг/

Үзүүлэлтүүд	2012	2013	2014	2015	2016
Нийгмийн даатгалын үйлчилгээ- бүгд	22852111.7	24922113.5	31050719.9	37836120.4	42298743.6
Өндөр настны тэтгэвэр	12553296.0	14065233.7	17260227.3	20399115.3	22676003.0
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэвэр	5386514.1	5731415.7	8196517.4	11313784.3	13335171.7
Тэжээгч алдсаны тэтгэвэр	4075395.0	4127698.5	4309517.4	4481603.7	4420142.0
Цэргийн албан хаагчийн тэтгэвэр	836906.6	997765.6	1284457.8	1641617.1	1817426.9


#### **НИЙГМИЙН ДААТГАЛДЫН ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДАГСДЫН ТОО**

Үзүүлэлтүүд	2012		2013		2014		2015		2016	
	бүгд	эмэгтэй	бүгд	эмэгтэй	бүгд	эмэгтэй	бүгд	эмэгтэй	бүгд	эмэгтэй
Нийгмийн даатгалд даатгуулагчийн тоо	12850	7758	15415	9290	15774	9637	13494	7530	17641	10408
Өндөр настны тэтгэвэр	6105	3724	6080	3726	6372	4105	6740	4144	7027	4286
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэвэр	3642	1590	3522	1530	3829	1849	4791	2336	5202	2653
Тэжээгч алдсаны тэтгэвэр	2501	1453	2390	1418	1748	1075	1637	1027	1543	972
Цэргийн албан хаагчийн тэтгэвэр	225	30	258	43	306	8	326	23	337	24


Хүн амын нийгмийн асуудлыг шийдвэрлэж, халамж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх явдал юм. Энэ ажлын хүрээнд 2016 онд нийгмийн даатгалын сангаас 7027 гаруй хүнд өндөр настны тэтгэвэр, 5202 хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгох тэтгэвэр, 1543 хүнд тэжээгч алдсаны тэтгэвэр, 337

хүнд цэргийн тэтгэвэр олгосон. Нийгмийн даатгалд датгуулагчдын тоо өмнөх оныхоос 30.7 хувиар өсч 17641 хүрсэн. Нийгмийн даатгалын сангаас нийт 42298.7 сая төгрөг зарцуулсан нь өнгөрсөн оныхоос 11.8 хувиар нэмэгдсэн буюу өссөн байна.


### НИЙГМИЙН ДААТГАЛД ЗАРЦУЛСАН ЗАРДАЛ



### НИЙГМИЙН ДААТГАЛД ХАМРАГДАГСАД



### НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГААС ЗАРЦУУЛСАН ХӨРӨНГӨ



2016 онд нийгмийн халамжийн сангаас 6621 гаруй ахмад настанд 454.6 сая төгрөгийн хөнгөлөлт тусламж, 1437 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдэд 289.9 сая төгрөгийн хөнгөлөлт, тусламж, 41424 хүнд нийгмийн халамжийн тэтгэвэрт 4801.9 сая төгрөг, 32416 хүнд нийгмийн халамжийн хөнгөлөлт, нөхцөлт мөнгөн тэтгэмжийнд 1069.0 сая төгрөг, 624 алдар цолтой ахмадуудад 110.5 сая төгрөгийн хөнгөлөлт, мөнгөн тусламж үзүүлсэн байна. Нийгмийн халамжийн сангаас 8956.2 сая төгрөг зарцуулсан нь өмнөх оноос 17.7 хувиар өссөн байна.

### НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГААС ОЛГОСОН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ /мянган төгрөг/

Үзүүлэлтүүд	2012	2013	2014	2015	2016
Нийгмийн даатгалын сангаас олгосон тэтгэмж -Бүгд	7086333.3	9061602.5	7701997.9	7608355.8	8956224.9
Жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн тэтгэмж	1255142.8	1366566.8	1423893.3	1363726.2	1422478.0
Ахмад настнуудыг асарч буй иргэнд олгох тэтгэмж	215576.4	278885.6	298481.9	353283.3	454644.2
Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч буй иргэний тэтгэмж	171203.6	192594.4	205921.6	207206.9	260890.2
Бүтэн өнчин хүүхэд үрчлэн өсгөсний тэтгэмж	74513.0	85566.4	81250.9	5886.6	81194.0
Ахмад настнуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	200376.4	372331.7	413784.7	268594.2	465743.5
Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдэд үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	167316.9	261783.9	217154.9	229283.4	289905.4
Нийгмийн халамжийн тэтгэвэр	4370236.7	5143858.4	4505442.7	4441166.2	4801869.5
Нийгмийн халамжийн хөнгөлөлт, нөхцөлт мөнгөн тусламж	529179.3	1250783.4	445930.6	618543.3	1069021.7
Алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	102788.2	109231.9	110137.3	120665.7	110478.4

Үзүүлэлтүүд	2012	2013	2014	2015	2016
Ахмад настнуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	1425	2051	9095	1726	6621
Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдэд үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	1224	1867	4335	1673	1437
Нийгмийн халамжийн тэтгэвэр	56973	49759	40500	38411	41424
Нийгмийн халамжийн хөнгөлөлт, нөхцөлт мөнгөн тусламж	21486	22839	19751	25667	32416
Алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	585	640	669	694	624

### ХҮН АМ ӨРХИЙН БҮРТГЭЛ-ХҮН АМ ӨРХИЙН МЭДЭЭЛЛИЙН САН

Хүн ам өрхийн бүртгэл нь тухайн өрхөд байгаа бүх хүний мэдээллийг бүртгэх бөгөөд тухайн оны суурин хүн амын тоог тодорхойлох, анхан шатны мэдээлэл

учраас цахим санд бүрэн оруулах, баяжилт хийх, шинэчилж байх нь их чухал байдаг. Хүн амын тооллогоо хоорондын хүн амын тоог хянах, суурин хүн ам, өрх, нийгмийн үзүүлэлтүүдийн талаархи мэдээллийн санг бүрдүүлэх, мэдээллийн эх үүсвэр нь хүн ам өрхийн бүртгэлийн дэвтэр юм. Манай аймгийн хувьд 14 засаг захиргааны нэгжийн 90 багийн хүн ам, өрхийн мэдээллийн цахим сан бүрдсэн. 2015 онд болж өнгөрсөн хүн ам орон сууцны завсрын тооллогын ажил бүртгэлд суурилж явагдсан учир Хүн ам, өрхийн мэдээллийн сан болон Улсын бүртгэлийн хэлтсийн Иргэний мэдээллийн сангийн хоорондын зөрүүг арилгах ажлыг эрчимтэй хийж, цэгцэлсэн бөгөөд хаягийн шинэчлэлд ороогүй хүмүүсийн мэдээллийг тодруулах, өрх бүрээр хаягжилт тогтоож, газар зүйн мэдээллийн санд өрхийн байршлын координатыг оруулж, кадастржуулах, газрын зураглалт байршлын цэгийг тэмлэглэх зэрэг ажлууд хийгдсэн. Регистрийн давхардалтай 94 хүний мэдээллийг цэгцэлж давхардлыг арилгасан, мөн урьд онуудад нас барьсан мөртлөө улсын бүртгэлийн иргэний мэдээллийн санд хасагдаагүй байсан 620 хүний мэдээллийг цэгцэлсэн. 2016 онд шинээр төрсөн 2831 хүүхэд, нас барьсан 515 хүн, тус аймаг шилжин ирсэн 64 өрхийн 270 хүн, шилжин явсан 498 өрхийн 2570, үүнээс удаан хугацаагаар Казахстан улсад амьдарч байгаа 2124 хүний мэдээллийг хүн ам, өрхийн мэдээллийн санд оруулж, цэгцэлж, баяжуулсан болно.

### ХАӨМС-ийн мэдээлэлийн сангийн хаягжилт, баяжилт

Сумын нэр	Нийт Өрхийн тоо	Байршил тодорхойлсон өрхийн тоо	Байршил тодорхойлоогүй өрхийн тоо	Шилжин явсан хүний тоо	Шилжин ирсэн хүний тоо
Алтай сум	1122	1071	43	7	6
Алтанцөгц сум	749	725	23	6	10
Баяннуур сум	1151	1115	39	16	7
Бугат сум	972	976	6	10	5
Булган сум	1183	1221	17	56	23
Буянт сум	768	746	22	12	5
Дэлүүн сум	1594	1578	54	10	2
Ногооннуур сум	1951	1893	52	39	16
Сагсай сум	1250	1153	103	4	4
Толбо сум	970	950	22	3	9
Улаанхус сум	1819	1766	64	23	7
Цэнгэл сум	2001	1948	65	20	10
Өлгий сум	7792	7770	145	240	166
Дүн	23322	22912	655	446	270

### ШИНЭЭР БИЙ БОЛСОН АЖЛЫН БАЙР, САЛБАРААР

2016 онд 1061 хүний ажлын байрны захиалга ирсэнээс 940 хүн зуучлагдаж ажилд орсон байна. 1113 хүн шинэ ажлын байртай болсны 15.1 хувь нь хөдөө аж ахуйн салбар, 33.6 хувь нь боловсруулах үйлдвэрт, 8.1 хувь нь барилгын салбарт, 10.3 хувь нь худалдаа үйлчилгээний салбарт, 17.2 хувь нь боловсролын салбарт, 2.2 хувь нь эрүүл мэндийн салбарт, 1.8 хувь нь зоогийн газарт бий болсон байна.

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	2012	2013	2014	2015	2016
Хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуй	551	79	191	203	168
Уул уурхай олборлох			264	9	31
Боловсруулах үйлдвэр	307	200	382	470	374
Цахилгаан эрчим хүч, дулаан, усан хангамж		11	11	7	
Барилгын салбарт	415	533	257	88	91
Бөөний ба жижиглэнгийн худалдаа	48	69	41	362	115
Зочид буудал зоогийн газар	26	101	24	46	21
Тээвэр, тээш хадгалалт, холбоо	15	72	17	19	
Санхүүгийн байгууллага	21	59	15	3	2
Төр захиргаа батлан хамгаалах	16	50	44	27	9
Боловсрол	71	55	104	180	192
Эрүүл мэнд	8	27	33	43	25
Нийтийн аж ахуйн, нийгмийн үйлчилгээ	34	161	153	26	2
Төсөл хөтөлбөр, дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа		507	64	37	
Энгийн ажил мэргэжил	16	132		31	83
<b>Дүн</b>	<b>1528</b>	<b>2056</b>	<b>1600</b>	<b>1551</b>	<b>1113</b>

### ШИНЭ АЖЛЫН БАЙРНЫ ЗЭРЭГЦҮҮЛЭЛТ





## ДҮГНЭЛТ

Манай аймаг баруун бүсийн аймгуудаас хүн амын тоогоор тэргүүлдэг аймаг юм. Баруун бүсийн хүн амын цэвэр өсөлт 22.0 хувьтай, улсын дундаж 21.3 хувьтай байхад манай аймаг 23.3 болж баруун аймгуудын дотор хамгийн өндөрт орж байна. Улсын дунджаас 2.0 пунктээр өндөр өсөлттэй байна. Энэхүү хүн амын өсөлтийг дагаж дундаж наслалт 3.44 насаар урт байна.

Аймгийн хүн ам өрхийн үндсэн үзүүлэлт, төлөв байдал судалгаанаас үзэхэд хүн амын цэвэр өсөлт улсын хэмжээнд нилээн дээгүүрт ордог.

- Аймгийн хэмжээнд 2016 оны байдлаар 23322 өрхтэй, түүний 53.0 хувь нь аймгийн төвд, 47.0 хувь нь хөдөөд байгаа бөгөөд дунджаар нэг өрхөд 4.3 хүн ногдож байгаа нь улсын дунджаас 0.6 хүнээр илүү байна.

-Сүүлийн үед, дэлхийн хүн амын сангийн нөхөн үржихүй эрүүл мэндийн хөтөлбөрийн хүрээнд явагдсан сургалт сурталчилгааны үр дүнд төрөлтийг гэр бүл төлөвлөлтөөр зохицуулдаг болсоноор хүн амын цэвэр өсөлт сүүлийн 5 жилд өсөн нэмэгдэж байна.

- Хүн амын дундаж наслалт уртсаж, 1000 хүнд ногдох төрөлт ихсэж, нас баралт өмнөх оноос 0.3 пунктээр буурсан байна.

- Энэхүү судалгаанаас үзэхэд хүн амын насны бүтэцэнд их өөрчлөлт гарч байна. Хүн амын 52.4 хувийг хөдөлмөрийн насны хүн ам, 42.3 хувийг хүүхэд, 5.1 хувийг өндөр настан эзэлж байна.

-Хүн амын шилжих хөдөлгөөн нэмэгдэх хандлагатай байна. Аймаг дотроо хөдөөнөөс төв рүү шилжих шилжилт, улсын томоохон хот суурин газар руу шилжих шилжилт үргэлжилсээр байна. Мөн хөдөлмөрийн гэрээгээр болон цагаачлахаар явагсадын тоо манай аймгийн үндэсний онцлогоос шалтгаалан цаашид үргэлжлэх хандлагатай байна.

Манай аймгийн хувьд шинээр бий болсон ажлын байрны ихэнх нь байнгын ажлын байр мөртлөө ажиллагсадын тоо нэмэгдэхгүй байна.

- Шинээр ажлын байр бий болгох, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татаж ажлын байр бий болгох, ажил олгогчийн зүгээс тухайн хүний нийгмийн баталгааг хангахад чиглэсэн тодорхой дэс дараатай арга хэмжээнүүд авагдахгүй байна.

Улмаар ажил хөдөлмөр эрхлээгүй хүний тоо бодитой буурахгүй байгаа ба шилжих хөдөлгөөнд оролцогчдын ихээнхийг ажил хөдөлмөргүй иргэд эзэлж байна.

Ядуу өрхийн тоо өмнөх жилээс 3.8 хувиар нэмэгдэж нийт өрхийн 30.8 хувийг эзэлж, нийт ядуу өрхөд нэн ядуу өрхийн эзлэх жин 55.6 хувь болж өмнөх оныхоос 2.2 хувиар нэмэгдсэн байна.

Сүүлийн жилүүдэд манайх чиг эрс тэс уур амьсгалтай өвөл нь хүйтэн, хүндрэлтэй сумдад цөөхөн тооны мал орлогын тогтвортой эх үүсвэрийг бүрдүүлж чадаагүйгээс сумдаас аймаг руу чиглэсэн дотоод хөдөлгөөн нэмэгдсээр сум, аймгийн төвийн хооронд өрхийн давхардал ихээр үүссэн байна.Энэ нь нэг талаас газар, үл хөдлөх хөрөнгийн өмчлөлтэй холбоотой

байна.

-Нийгмийн халамж, нийгмийн даатгалын хамрах хүрээ өргөжиж, эдгээр нийгмийн үйлчилгээ эмзэг бүлгийн хүн амын амьжиргааг дээшлүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагаа болж байгаа ба цаашид хүртээмжийг сайжруулахад анхаарлаа хандуулах хэрэгтэй байна.

- Манай аймгийн хувьд хүн амын өвчлөлийн хамгийн их тохиолддог нь амьсгалын замын тогтолцооны өвчин, шээс бэлгийн замын тогтолцооны өвчин, нас баралтаар тэргүүлж байгаа нь цусны эргэлтийн тогтолцооны өвчлөл бөгөөд мэргэжлийн байгууллагын дүгнэлтээр уулархаг газар нутагтай далайн түвшинээс өндөр байгаа нь нөлөөлж байна.Цусны эргэлтийн тогтолцооны өвчнөөр өвчлөгсдийн 18 тохиолдолын нэг нь нас баралтад хүргэж байна.

Эхийн эндэгдэл болон нялхасын эндэгдэл бол эрүүл мэндийн чанарын гол үзүүлэлт болдог.2016 онд эхийн эндэгдэл гараагүй бөгөөд харин нялхасын эндэгдэл 79 гарч өмнөх оноос 10 хүүхэд буюу 14.5 хувиар өссөн байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо 2014 онд 4461, 2015 онд 4551, 2016 онд 4564 хүн болж өмнөх оноос 0.3 хувиар нэмэгдэж, нийт хөгжлийн бэрхшээлтэй хүний 52.1 хувийг эмэгтэйчүүд, 4.7 хувийг хүүхэд, 60.9 хувийг төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй хүн эзэлж байна.

## АШИГЛАСАН НОМ, МАТЕРИАЛ

1. Баян-Өлгий аймгийн Статистикийн эмхэтгэл 2011- 2016 онууд
2. Улсын Статистикийн эмхэтгэл 2011- 2016 онууд
3. Албан ёсны болон захиргааны сар, улирал, жилийн эцсийн мэдээ
4. Монгол улсын мянганы хөгжлийн шалгуур үзүүлэлтүүд
- 5.Хүн ам орон сууцны 2015 оны завсрын тооллогын урьдчилсан дүн мэдээ
- 6.Монгол улсын нийгмийн хамгааллын хөтөлбөрүүдийн хэрэгжилт, үнэлгээ

УБ хот 2016 он

\_\_\_\_\_ о О о \_\_\_\_\_